



ТОРГОНЫ ЗАМЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ: УУЛ УУРХАЙН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА - I ТАЙЛАН

Байршил: Монгол Улсаас БНХАУ-д суугаа Элчин сайдын яам

Зорилго: Монгол улсын уул уурхайн салбарт төсөл хэрэгжүүлэх сонирхолтой хөрөнгө оруулагч нарт шаардлагатай цогц мэдээлэл хүргэх

Зохион байгуулагч нар:

- Тригтек ХХК
- Монголын Уул Уурхайн Үндэсний Ассоциаци
- Эм Ай Си Си ҮЦК ХХК
- Өмгөөллийн Легал Полиси ХХК

ХӨТӨЛБӨР

14:00 – 14:30	Бүртгэл	
14:30 – 14:40	Нээлтийн үг	Тригтек-ийн гүйцэтгэх захирал Г.Цолмон
14:40 – 15:10	Эрдэс баялгийн салбарын хууль эрх зүйн орчин, хариуцлагатай уул уурхай	Монголын Уул Уурхайн Үндэсний Ассоциацийн Гүйцэтгэх Захирал Г.Эрдэнэтуяа
15:10 – 15:25	“Хан-Алтай” төслийн танилцуулга	Монголын Уул Уурхайн Үндэсний Ассоциацийн Гүйцэтгэх Захирал Г.Эрдэнэтуяа
15:25 – 15:40		Кофе завсарлага
15:40 – 15:55	“Ухаа худаг-1” төслийн танилцуулга	Тригтек-ийн хөрөнгө оруулалтын аналит, ахлах геологич Г. Гүнбилэг
15:55 – 16:10	Байгууллагын танилцуулга: • Эм Ай Си Си ҮЦК ХХК • Өмгөөллийн Легал Полиси ХХК • Тригтек ХХК	
16:10 – 16:50	"Хөрөнгө оруулалтын анхдагч алхмууд, анхаарах хүчин зүйлс" хэлэлцүүлэг	
16:50 – 18:00	Нээлттэй ярилцлага	

ТАЙЛАН

Монгол Улсаас БНХАУ-д суугаа ЭСЯ-ны дэргэдэх Монголын соёл, мэдээллийн төвд 2023 оны 12-р сарын 21-ний өдөр Геологи, уул уурхайн инженерчлэлийн зөвлөх үйлчилгээ үзүүлэгч “Тригтек” ХХК-ын зүгээс санаачлан, Монголын Уул Уурхайн Үндэсний Ассоциаци, “Эм Ай Си Си ҮЦК” ХХК, Өмгөөллийн “Легал Полиси” ХХК хамтран “Торгоны замын Хөрөнгө оруулалт: Уул уурхайн төслийн танилцуулга” арга хэмжээг зохион байгууллаа.

Арга хэмжээг нээж **Тригтек ХХК-ын захирал Г. Цолмон** хэлсэн үгэндээ: “Монгол улсын уул уурхайн салбарт хөрөнгө оруулагчдад цогц мэдээлэл хүргэх, шууд хөрөнгө оруулах боломжтой төслүүдийг танилцуулах, хууль эрх зүйн болон эдийн засгийн бодит өгөөжийн талаар салбарын мэргэжилтнүүдийн зөвлөгөөг хүргэж, хэвшмэл сөрөг ойлголтыг арилгах, улмаар уламжлал болгон өргөжүүлэн зохион байгуулж, бодит үр дүнд хүрч ажиллах нь энэхүү арга хэмжээний үндсэн зорилго юм” хэмээн онцоллоо.

Хөтөлбөрийн дагуу **Монголын Уул Уурхайн Үндэсний Ассоциацийн гүйцэтгэх захирал Г.Эрдэнэтуяа** “Эрдэс баялгийн салбарын хууль эрх зүйн орчин, хариуцлагатай уул уурхай” сэдвийн хүрээнд МУУҮА-ын үндсэн үйл ажиллагаа, зорилго чиглэл, хэрэгжүүлж буй томоохон төсөл хөтөлбөрүүд, тэр дундаа хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх чиглэлээр хэрэгжүүлж буй арга хэмжээ болон МУ-ын уул уурхайн салбарын өнөөгийн нөхцөл байдал, хууль эрх зүйн орчны талаар танилцууллаа.

Мөн гаднын хөрөнгө оруулагчдын өмнө тулгамдаж буй үндсэн асуудал нь хууль эрх зүйн талын мэдлэг мэдээлэл дутмаг байгаагаас шалтгаалан зайлшгүй шаардлагатай баримт бичиг, төлөвлөгөө тайлан зэргийг цаг хугацаандаа хүлээлгэн өгдөггүй, үүнээс үүдэн тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, аливаа залилангийн хохирогч болох эрсдэл үүсдэг, нөгөө талаас орон нутгийн иргэдтэй үл ойлголцол үүсгэснээс үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх боломжгүй болох зэрэг асуудалтай тулгардаг бөгөөд холбогдох хуульд заасны дагуу, дүрэм журмыг мөрдөн ажилласнаар эдгээр асуудлыг бүрэн шийдвэрлэх боломжтой талаар онцолсон юм.

Илтгэлийн төгсөлд МУ-ын Засгийн газрын зүгээс хөрөнгө оруулагчдыг дэмжих чиглэлд авч хэрэгжүүлж буй бодлого, татварын хөнгөлөлтийн талаар мэдээлэл өгч, МУУҮА-ийн зүгээс “Хариуцлагатай уул уурхай” хөтөлбөрөөр дамжуулан хөрөнгө оруулагчдад хууль эрх зүйн хүрээнд харилцан ашигтай ажиллах боломжийг нэмэгдүүлэх чиглэлд бүхий л талаар нээлттэй, дэмжин ажиллахаа илэрхийллээ.

ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Энэ удаагийн арга хэмжээний бас нэгэн онцлог нь шууд хөрөнгө оруулалт татах боломжтой, эдийн засгийн өндөр ач холбогдол бүхий уул уурхайн төслүүдийг танилцуулсан бөгөөд Говь-Алтай аймгийн нутаг дахь Хан Алтай алтны орд болон Өмнөговь аймгийн Манлай сумын нутагт байрлах “Ухаа-Худаг 1” алтны ордны төслийг тус тус танилцууллаа

Арга хэмжээний дараагийн хэсэгт зохион байгуулагч Монгол улсын уул уурхайн салбарт хөрөнгө оруулалтын зөвлөх үйлчилгээг хамтран гүйцэтгэж буй компаниудын төлөөлүүд өөрсдийн үйл ажиллагааны чиглэлийн талаар товч танилцуулга хийж, оролцогчдын сонирхсон асуултад хариулсан юм.

Эм Ай Си Си ҮЦК ХХК

Илтгэгч: “Эм Ай Си Си ҮЦК” ХХК-ийн Хөрөнгө оруулалтын ахлах шинжээч, Б.Назим МІСС нь 2005 онд үүсгэн байгуулагдсан бөгөөд Монгол Улсад анхны хөрөнгө оруулалтын банкны үйлчилгээг санал болгосон компани юм. Байгуулагдсан цагаасаа хойш бид харилцагчдадаа хоёр тэрбум гаруй ам.доллар босгож, 100 гаруй хэлцлийг амжилттай хийсэн бөгөөд харилцагчдынхаа бизнесийг өргөжүүлэх, илүү хямд хөрөнгө оруулалтын эх үүсвэр олох, компанийнхаа үнэ цэнийг нэмэгдүүлэхэд тусалсан.

Үйл ажиллагааны үндсэн чиглэлийн хувьд Эм Ай Си Си ҮЦК нь санхүүгийн зөвлөх үйлчилгээ, хөрөнгө оруулалт босгох үйлчилгээ, худалдааны санхүүжилтийн үйлчилгээ болон стратегийн зөвлөх үйлчилгээ үзүүлдэг. Түүнчлэн Монголын болон олон улсын хөрөнгийн зах зээлд оролцогч хуулийн этгээд болоод хувь хүмүүст брокерын үйлчилгээ үзүүлдэг бөгөөд харилцагчдадаа бизнесийн шинэ боломжуудыг тодорхойлох, үнэлэхэд нь туслах зорилгоор зорилтот зах зээлийн судалгааг хийдэг.

МІСС нь Монгол Улсын Засгийн газар болон цөмийн эрчим хүч нийлүүлэгч “Orano Mining SAS” компанийн хооронд Франц-Монголын төслийн Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах ажлын хэсгийн зөвлөхөөр ажиллаж байна. .

“Эрдэнэс Тавантолгой” ХК нь Монгол Улсын ТОП-5 компанийн нэг бөгөөд стратегийн ач холбогдол бүхий Тавантолгойн нүүрсний ордод үйл ажиллагаа явуулдаг хаалттай хувьцаат компани юм. МІСС нь 2021-2025 онд бизнесээ өргөжүүлэх төлөвлөгөөгөө хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийг босгох зорилгоор "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн санхүүгийн зөвлөх, андеррайтераар ажилласан. .

Өмгөөллийн Легал Полиси ХХК

Илтгэгч: Өмгөөллийн Легал Полиси ХХК-ийн зөвлөх Г. Гүнчин

Бид өмгөөллийн болон хууль зүйн зөвлөх үйлчилгээний салбарт 15 жилийн туршлагатай, иргэн, захиргаа, эрүүгийн эрх зүйн чиглэл тус бүрээр мэргэшсэн олон жилийн туршлага, ур чадвартай хуульчдын багаас бүрдсэн, томоохон төслүүдэд зөвлөх үйлчилгээ үзүүлэгч, үйлчлүүлэгчдийнхээ итгэлийг хүлээсэн, олон улсын нэр хүндтэй хуулийн фирмүүдтэй хамтын ажиллагаатай, бизнесийн өндөр соёлыг төлөвшүүлэхийг эрмэлзэгч байгууллага юм.

Үйл ажиллагааны үндсэн чиглэл: Өмгөөлөл, хууль зүйн зөвлөх үйлчилгээ, сургалт судалгаа шинжилгээ, хууль зүйн баталгаат орчуулга

Өмгөөллийн үйлчилгээ

1. Иргэний эрх зүйн хэрэг, маргааны хүрээнд:

- Шүүхийн болон шүүхийн бус журмаар хэрэг маргаан шийдвэрлэхэд үйлчлүүлэгчийг төлөөлөх;
- Нэхэмжлэлийн төсөл боловсруулах, нэхэмжлэлийн шаардлага нэмэгдүүлэх, нотлох баримт бүрдүүлэх, нэхэмжлэлийн хариу тайлбар боловсруулах, сөрөг нэхэмжлэл гаргах, хүсэлт гаргах;
- Тухайн хэрэгтэй холбогдуулан төрийн эрх бүхий байгууллагад гомдол, хүсэлт, өргөдөл гаргах;
- Тухайн хэрэг маргаанд холбогдуулан бусад шаардлагатай эрх зүйн зөвлөгөө өгөх;
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд оролцох

2. Захиргааны эрх зүйн хэрэг, маргааны хүрээнд:

- Шүүхийн болон урьдчилсан шийдвэрлэх ажиллагаанд үйлчлүүлэгчийг төлөөлөх;
- Тухайн хэрэг маргаантай холбогдуулан захиргааны байгууллага, албан тушаалтанд гомдол, хүсэлт, өргөдөл гаргах, шүүхэд нэхэмжлэл, нэхэмжлэлийн хариу тайлбар, сөрөг нэхэмжлэл гаргах;
- Шаардлагатай бусад эрх зүйн зөвлөгөөг үйлчлүүлэгчид өгөх.
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд оролцох

3. Эрүүгийн эрх зүйн хэргийн хүрээнд:

- Мөрдөн байцаах ажиллагаа, шүүхийн шатанд өмгөөлөгчөөр оролцох;
- Байцаан шийтгэх ажиллагааны хүрээнд хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, шүүхэд, гомдол хүсэлт гаргах;
- Шаардлагатай бусад эрх зүйн зөвлөгөөг үйлчлүүлэгчид өгөх.

4. Арбитр

- Арбитрын ажиллагаанд талуудыг төлөөлж, мэдүүлэг, мэдүүлэг болон бусад холбогдох эрх зүйн баримт бичгийн төслийг боловсруулах.

Хууль зүйн зөвлөх үйлчилгээ

- Хууль зүйн зөвлөгөө
- Баримт бичгийн төсөл, баримт бичгийг хянан үзэх
- Зохицуулалт
- Төлөөлөгч

Тригтек ХХК

Илтгэгч : Тригтек ХХК -ийн хөрөнгө оруулалтын аналит, ахлах геологич Г. Гүнбилэг

Тригтек ХХК нь геологи, уул уурхайн инженерчлэлийн чиглэлээр мэргэшсэн Монголын 100 хувийн хөрөнгө оруулалттай зөвлөх үйлчилгээний компани юм.

Манай төв оффис Улаанбаатар хотод байрладаг. Мөн бид БНХАУ-ын Шандун мужийн Жинань, Казакстан улсын Астана хотуудад албан ёсны бүртгэлтэй төлөөлөгчийн газартай.

Бид Австрали, Канад, АНУ зэрэг уул уурхайн тэргүүлэгч орнуудын хамгийн сүүлийн үеийн технологийн шийдэл, бүтээгдэхүүнийг албан ёсны эрхтэйгээр Төв Ази, Өмнөд Солонгос, Хятад, Монгол дахь хэрэглэгчдэдээ хүргэж үйлчилж байна.

Хөрөнгө оруулалтын зөвлөх үйлчилгээний хувьд:

- ✓ Хөрөнгө оруулалтын бүх төрлийн зөвлөгөө
- ✓ Гуравдагч талын техникийн хяналт, хайгуул, уул уурхайн хөрөнгө оруулалтад шаардлагатай шалгалт дүгнэлт гаргах
- ✓ Хөрөнгө оруулагчид нийцүүлсэн тайлан ба үнэлгээний тайлан

Түүнчлэн:

- Дижитал шилжилтийн зөвлөгөө
- Ашигт малтмалын үнэлгээ ба QA/QC зөвлөгөө
- Геотехникийн болон гидрогеологийн зөвлөгөө
- Өрөмдлөгийн менежментийн программ хангамжийн шийдэл
- 3D загварчлалын төрөл бүрийн геологийн программ хангамжийн шийдлүүд
- Газрын тос, байгалийн хийн программ хангамжийн шийдэл

ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

Илтгэгчид танилцуулга хийж дууссаны дараа "Хөрөнгө оруулалтын анхдагч алхмууд, анхаарах хүчин зүйлс" сэдвийн хүрээнд хэлэлцүүлэг өрнүүлж, нийт оролцогчдын сонирхсон асуултад хариулт өглөө.

Тус арга хэмжээнд Хятадын 20 гаруй аж ахуй нэгжийн төлөөлөл оролцсон бөгөөд хөрөнгө оруулагчдад нэн шаардлагатай МУ-ын уул уурхайн салбарын шинэлэг мэдээлэл, хууль эрх зүй болон эдийн засаг, хөрөнгийн зах зээлийн нөхцөл байдлын талаар цогц мэдээлэл өгсөнд талархалтай байгаагаа илэрхийлж байлаа.

Хэлэлцүүлгийн явцад оролцогчид ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн ангилал болон түүнтэй холбогдох төлбөр, стратегийн ач холбогдолтой ордын ашиглалтын талаар, мөн цацраг идэвхт болон газрын ховор элементийн ордод хөрөнгө оруулахад Засгийн газрын зүгээс аливаа хязгаарлалт тавьдаг эсэх зэрэг талаар асуулт тавьж, өөрсдийн санал бодлыг мөн илэрхийлсэн юм.

Арга хэмжээний төгсгөлд зохион байгуулагчид болон оролцогчдын хооронд харилцан танилцах, цаашдын хамтын ажиллагааны боломжуудын талаар мэдээлэл солилцох нээлттэй ярилцлагыг зохион байгууллаа.

Бидний санаачилгыг дэмжин Монгол Хятад хоёр улсын уул уурхай, хөрөнгө оруулалтын салбарын хамтын ажиллагааг нэмэгдүүлэхэд өндөр хувь нэмэр оруулсан Монгол улсаас БНХАУ-д суугаа Элчин сайдын яамны хамт олонд онцгойлон талархал илэрхийлье!

АРГА ХЭМЖЭЭНД ОРОЛЦОГЧИД

1. China Mining Association
2. The 7th Geological Brigade of Henan Yudi Technology Group
3. Henan Yudi Science and Technology Group Co., Ltd.
4. Mining Professional Committee of China Asia Economic Development Association
5. Shanghai Tongzheng Mining Co., Ltd.
6. Global Haoyuan Fund Company
7. Geocentric Interactive Company
8. HG Parma (Canada)Inc.
9. Hong Kong Express (Mongolia) Company
10. Nonferrous Research Institute has research funding environment/GRINM
11. Shanghai Cooperation Organization National Multifunctional Economic and Trade Platform
12. Liaoning Development Group Trading Co., Ltd.
13. Tongde (002360) New Energy Resources Development Co., Ltd.
14. Ansheng Silk Road Wet Method Project Company
15. BEIJING INSTITUTE OF GEOLOGY FOR MINERAL RESOURCES CO., LTD. (BIGM)
16. Deep Exploration (Beijing) Technology Co., Ltd.
17. BEIJING SOLY TECHNOLOGY CO.LTD
18. Lihong Inspection Group Co., Ltd.
19. Huayu Mining